



ХЭЛТСҮҮДИЙН 2025 ОНЫ 03 ДУГААР САРЫН 31-НЭЭС 2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 04-НИЙ ӨДРҮҮДЭД ХИЙХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ



2025 оны 03 дугаар сарын 31-ний өдөр

ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР



ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

1. Аймгийн Засаг даргын Тамгын даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийг хуралдуулах.
2. Төрийн албан хаагчдын хойд бүсийн “Бүсчилсэн хөгжил- төрийн албаны манлайлал” зөвлөгөөний бэлтгэл ажлыг хангах
3. ХХААГ -ийн даргын албан тушаалын тодорхойлолтыг баталгаажуулан хүргүүлэх.
4. ХБНГУ-аас Монгол улсад суугаа Элчин сайд аймгийн удирдлагуудтай хийх уулзалтыг зохион байгуулах.





ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

1. Ажлын хэсгийн хурлаар Уурхайчин багт үйл ажиллагаа явуулж буй “Хүлэг” хүнсний захыг нүүлгэх асуудлыг хэлэлцүүлэх.
2. Эрдэнэт ШУТП-дээр байгаа хөнгөлөлттэй зээлийг Баян-Өндөр, Жаргалант сумдад шилжүүлэх ажлыг дуусгах.
3. 2026 онд аймгийн нутаг дэвсгэрт хууль тогтоомжийн дагуу ашиглах байгалийн нөөцийн төрөл, дээд хэмжээний саналыг нэгтгэн гаргаж Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яаманд хүргүүлэх.





НИЙГМИЙН БОДЛОГЫН ХЭЛТСИЙН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

1. Дэлхийн эмч нарын өдрийн баярын хурлыг зохион байгуулах.
2. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн сургалт эрхлэх зөвшөөрлийн мэдээллийг зөвшөөрлийн нэгдсэн санд оруулах.
3. ЕБС-иудад хэрэгжиж буй “Сүү” хөтөлбөрийн зардлыг аймгийн Засаг даргын захирамжаар шийдвэрлүүлэх.
4. Ахмад, залуучууд, эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхэд гэр бүл зэрэг хүн амын бүлгүүдийн төлөөлөлүүдтэй хэлэлцүүлэг зохион байгуулж “Хүн амын бүлэг нийгмийн салбарын хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгах санал авах, төлөөлөгчдөөс болон бүлгүүдийн гаргасан саналыг тусган төлөвлөгөөг боловсруулж батлуулах.
5. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах салбар зөвлөл, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөл, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын салбар комиссуудыг хуралдуулах, зөвлөлүүдийг захирамжаар шинэчлэн байгуулах.
6. Хүүхэд хүмүүжлийн эерэг арга зүйн “Токкацү” арга зүйн сургалтыг бага ангийн багш нарт үе шаттай зохион байгуулах.



САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТСИЙН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

1. Төсвийн гүйцэтгэлийн 3 дугаар сарын мэдээг хянан баталгаажуулах
2. Аймгийн 2025 оны төсвийн хуваарийн өөрчлөлтийг захирамжаар шинэчлэн батлуулах
3. Иргэдийн төсөв - 2025 боловсруулах
4. Цахим санхүүгийн тайлангийн И баланс системд санхүүгийн тайлангаа илгээсэн ААНБайгууллагуудын санхүүгийн тайланг хүлээн авч хянан батлагаажуулах ажлыг дуусгах





ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТСИЙН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

1. Аймгийн ИТХ-ын Нийгмийн хөгжлийн хорооноос ирүүлсэн албан бичгийн дагуу "Сэтгэц нийгмийн сэргээн засах төв" байгуулах чиглэлээр судалгаа хийх, удирдамж боловсруулж танилцуулах.
2. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулга буюу Нийтийн өмчийн тухай хуулийн төсөлтэй танилцаж, холбогдох байгууллагуудаас саналыг авч нэгтгэн ЗГХЭГ-т хүргүүлэх.
3. ТАЗ-ийн Бүсчилсэн зөвлөгөөний хариуцсан салбар хэлэлцүүлгийн ажлын хэсэгт орж ажиллах.
4. “Ногоон очир” ХХК-ний нийлүүлсэн “Авто замын цэвэрлэгээний зориулалтын техник хэрэгсэл”-д инженерийн дүгнэлт гаргуулах, гэрээний үүргийг биелүүлэхтэй холбоотой асуудлаар хурал зохион байгуулах.
5. Орхон аймаг дахь Иргэний хэргийн шүүх хуралд бэлтгэж оролцох./Хэрлэн зураглал ХХК,/ Мөн Хас банкны нэхэмжлэлтэй захиргааны хэргийн анхан шатны шүүхэд тайлбар хүргүүлэх



ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТСИЙН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

6. Эрчим хүчний яамны 11/03 дугаартай удирдамжийн дагуу “Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт хяналт шалгалт хийх.
7. Баримт нягтлан шалгах арга зүйн комиссыг хуралдуулж хөмрөг үүсгэгч байгууллагуудаас ирүүлсэн устгах хэргийн актыг хэлэлцэх.





ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

1. “Ач санах”, “Анхдагч”, “Эмэгтэйчүүд, Залуучуудын хөгжлийн хөтөлбөр”-үүдийн 2021-2024 оны хэрэгжилтийн үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг гүйцэтгэх.
2. “Бүсчилсэн хөгжил-Төрийн албаны манлайлал” хойд бүсийн зөвлөгөөнд хариуцсан ажлын чиглэлээр бэлтгэл ажлыг хангах .
3. Улсын үнэлгээний чадавхын индекс тогтоох үнэлгээний асуумжийг нэгтгэн гаргаж Засгийн газрын ХХГ-т хүргүүлэх.





АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА

НАЙРАМДАЛ - ДРЧУЖДА

2024 он

